

“АЧИР” ХХК



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМ**  
**“АЧИР”ХХК-ИЙН ЧУЛУУН НҮҮРС УГААН БАЯЖУУЛАХ**  
**ҮЙЛДВЭРИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН**  
**ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ХЯНАСАН:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн ..... / Ц.Жаргалнэмэх /

ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАСАН:

“Ачир” ХХК-ийн захирал ..... / Ли Ганг /

“Ачир” ХХК-ийн БО-ны мэргэжилтэн ..... / М.Энэбиш /




Улаанбаатар хот 2023 он

АГУУЛГА.....	1
ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2 - 29
ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	30 – 31
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	31
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	32 - 49
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	50
ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	50 – 53
НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	54
ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	54
ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	54 - 55
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	56 – 61
ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	62 - 63
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	64 - 66
ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	67
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	68 - 76
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ.....	76 - 77
ДҮГНЭЛТ.....	77

## ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### Төсөл хэрэгжиж буй газрын засаг захиргааны харьяалал

“Ачир” ХХК нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Элдэв багийн нутагт нүүрс угаан баяжуулах үйлдвэрлэл эрхэлж нийт 60 га газарт үйл ажиллагаа явуулдаг. “Алагтолгой” нэртэй нүүрсний бүлэг ордыг түшиглэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортонд гаргах зорилготой. Цахим хаягаар РР-000039 тусгай зөвшөөрлийн дугаараар ханддаг. Регистрийн дугаар-6191614, улсын бүртгэлийн дугаар- 9019084117. Төслийн талбайн байршлын



хувьд “Монголын Алт” ХХК-ийн ашиглаж байгаа Элдэвийн нүүрсний уурхайгаас баруун тийш 8км, Улаанбаатар хотоос зүүн урагш 270 км, Төмөр замын 25-р зөрлөг болон Улаанбаатар-Сайншандыг холбосон автозамаас 18 км, Даланжаргалан сумаас баруун хойш 25 км-т байрладаг.

### Дэд бүтэц, зам харилцаа

УБ хотоос төмөр замын 25-р зөрлөг хүртэл хатуу хучилттай замаар зорчино. Цааш уурхайн талбай хүртэл автомашинаар зорчихдоо бартаа саадгүй сайжруулсан шороон замын сүлжээтэй.

Уурхайн карьер, хөрсний овоолго, кемп, засварын газрууд нь хоорондоо шороон замаар холбогдсон. Уурхайгаас “МАК” ХХК-ийн сайжруулсан нүүрс тээврийн зам хүртэлх замын даланг уурхайн хөрс хуулалтаас гарсан хөрсөөр хийсэн ба технологийн тээврийн зам нь 20 м өргөнтэй нийт 1.4 км замын суурь нь 0.45 м зузаан, 0,25 метр хайрган хучилттай бөгөөд цаг агаарын байдалд тэсвэртэй, ус урсах боломжтой 100 хүртэл тонны даацтай тээврийн хэрэгслүүд явахад зориулагдсан. Харилцаа холбооны хувьд үүрэн телефоны оператор компаниудын сүлжээ нэвтэрсэн.

### Физик газарзүй

Үйлдвэрийн талбай нь намхан толгод зонхилсон тал хээрийн бүсэд багтах бөгөөд хамгийн өндөр цэг нь уурхайн талбайгаас зүүн хойш 3.7 км-т байрлах 1352.2 тоот өндөрлөг бол нам доор цэг нь уурхайн талбайгаас баруун тийш 7 км-т байрлах Бэхтийн-Улаан нуур /1179.6 м/ юм. Харьцангуй өндөржилт нь 50 м-с хэтрэхгүй.

### *Байгаль цаг уурын нөхцөл*

Нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн талбайн орчин тойрон нь эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай. Даланжаргалан сум болон түүний орчин тойрны цаг уурын элементүүдийн сүүлийн 10 жилийн ажиглалтын дунджаар 16.5 мм хур тунадас унах бөгөөд үүний ихэнх нь 4-10-н сарын хооронд унана. 7-р сард дулааны дундаж хэм +25 градус, 01 сард -23 градус хүрч хүйтрэнэ. Дулааны улиралд +10 градусаас дээш хугацааны нийлбэр 2000-2800 градус, ургамал ургалтын үе нь 120-130 хоног байдаг. Жилийн туршид гол төлөв баруун зүгийн салхи зонхилох ба 4, 5 саруудад салхины хүч эрчимждэг.

### *Хөрсөн бүрхэвч*

БОНБНУ-ний хүрээнд хийгдсэн хээрийн судалгааны үр дүнд тус төслийн талбай орчим нь хөрс газарзүйн мужлалтын хувьд Хангайн их мужийн өргөрөгийн бүсшилттэй нутгийн Цайвархүрэн хөрсний дэд бүсийн хүрээнд Баяндэлгэрийн хөрсний тойрогт хамрагдаж байна. Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь хуурай хээр, говийн бүсийн зааг толгодорхог ландшафт зонхилсон бөгөөд толгодын хэсгээр сайргархаг цайвархүрэн хөрс, харьцангуй тэгшивтэр гадаргаар карбонаттай цайвархүрэн хөрс, хөндий хотгорын хэсгээр хужирлаг бараан, зузаан элсэнцэр цайвархүрэн хөрс тус тус тархсан.

### *Ургамлын аймаг*

Төслийн талбай нь ургамлын мужлалаар Төв Азийн тал талархуу газрын ургамалжил бүхий Евразийн хээрийн их муж, хуурайдуу хэв шинжийн Алтанширээгийн тойрогт багтдаг ба газрын гадаргын хувьд цав толгод ухаа гүвээ, хотос хотгор, тойром бүхий гадарга зонхилох бөгөөд голлон тааралдах ургамлын хэв шинж нь бэсрэг уулсын налуу хажуу тал хөндийд крыловын хялгана-сөөгөнцөр, таана-сайрын хялгана, говийн хялгана-заримдаг сөөгөнцөр, дэрс бүхий таана-бударгана зэрэг цөлөрхөг хээрийн бүлгэмдэл зонхилсон байх бөгөөд элсэрхэг сайргархаг тэгш талархаг талаар Зүүнгарын улаанбударгана, сэдэргэнэ, таана зэрэг цөл хээрийн ургамалжилттай.

### *Гадаргын болон гүний ус*

Ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савын бүсэд хамаарах бөгөөд гидрогеологийн мужлалаар улирлын хомс тэжээлтэй мужид байрладаг. Энэхүү ай савд гол мөрний сүлжээ маш бага бөгөөд нэгж талбайд ноогдох голын нийлбэр урт нь 0.01 км/км. кв-аас доош байдаг. Даланжаргалан сумын нутаг нь “ Умард Говийн Гүвээт-Халхын Дундад Тал” усны сав газарт хамаарах бөгөөд гадаргын ус бараг байхгүй ба унд ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээнд газрын доорх усыг ашигладаг. Сансрын болон геологи-техтоникийн зураг, усны эрэл хайгуулын судалгааны дүнгээс харахад техтоникийн хагаралын бүсэд оршдог. Нүүрсний үе, давхраасууд нь синклиналь тогтоцтой, харьцангуй бага гүнд байрлах ба 5-10 градусын уналтай ба геологи, тектоникийн тогтоц нь энгийн бүтцийг үүсгэнэ. Усжилт бүхий тектоникийн хагарал, ан цав багатай, тохрол, өргөгдөл, суултанд олон удаа орсон блок байхгүй байна. Ул суурийн хурдас нь уст үе, давхарга багатай шаварлаг хурдас тухайлбал



хар, хар саарал өнгийн аргиллит, алевролит, алевро-элсэнчулуу, шаварлаг чулуулгаас тогтох ба усжилт бага байдаг онцлогтой. Ордын гидрогеологийн нөхцлийн хувьд дээрх хүчин зүйлүүд **энгийн** нөхцөлтэй ангилалд оруулах боломжийг бүрдүүлж байна.

### *Амьтны аймаг*

“Ачир” ХХК-ийн нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн ойр орчим говь, цөлийн амьтад голчлон тархсан ба ихэнх нь “Монгол орны 2 нутагтан, мөлхөгчдийн улаан данс-2006 он”, “Монгол орны шувууны улаан данс-2011 он “Бүс нутгийн болон олон улсын үнэлгээний анхааралд өртхөөргүй /LC/ буюу өргөн тархац нутагтай элбэг гэсэн зүйл ангилалд орсон байна. Алагтолгой орчмын нүүрсний орд нь олон жилийн турш уул уурхайн хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөний улмаас амьтны аймгийн төрөл зүйлээр ядмаг юм.

### *Түүх соёлын дурсгалт газрууд*

“Блюскай Хорс” ХХК-ийн хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд 2014 онд ШУА-ийн Палеонтологийн төвийн доктор Н.Ичинноровоор ахлуулсан баг судалгааны ажлыг хийсэн ба талбайд археологийн болон соёлын үнэт зүйл бүхий зүйлс илрээгүй байна.

### *Нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн технологи*

Нүүрс угаан баяжуулах үйлдвэр нь ашигт малтмал баяжуулалтын гравитацын арга буюу тунаан баяжуулах технологийн дагуу нойтон аргаар баяжуулдаг үйлдвэр юм.

Баяжуулах үйлдвэрийн технологийн процесс нь түүхий нүүрс бэлтгэх хэсэг, угаан баяжуулах хэсэг, хаягдлын аж ахуйн хэсэг гэж ангилагдана.

**Нүүрс бэлтгэх хэсэг:** Баяжуулах үйлдвэрт нийлүүлэх нүүрсийг ил уурхайгаас олборлож байгаа учир мөхлөг нь харьцангуй том ширхэглэлтэй байх ба энэ нь үйлдвэрийн технологид нийцэхгүй тул нүүрсийг хацарт бутлуураар бутлан 200х200 мм-ийн сам шигшүүрээр шигшин технологид нийцүүлэн тэжээнэ.

Бункерийн дээд сараалжин торны нүхээр багтахгүй овор хэтэрсэн +200мм ширхэглэлтэй бутлан үйлдвэрийн бүтээлийг ихэсгэх шаардлага гарсан тул хацарт бутлуурыг шинээр суурилуулсан.

Бункерийн гарах амсрын доор байрлах тэргэнцэр тэжээгүүрийн ачааллыг нэмэх болон хасах замаар үйлдвэрийн бүтээл, ачааллыг тохируулах бөгөөд -200+0мм-ийн ширхэглэлтэй нүүрсийг туузан дамжуулагчаар тээвэрлэн шигшин ангилах доргиурт шигшүүрт тэжээнэ.

Шигшин ангилах доргиурт шигшүүрт түүхий нүүрсийг туузан дамжуулагчийн тусламжтайгаар тэжээх ба туузан дамжуулагч нь хаягдал төмөр ялгах соронзон төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

Доргиурт шигшүүрийн торны нүх нь 50мм байх ба шигшүүрийн дээд том нүүрс нь туузан дамжуулагчаар тээвэрлэгдэн булт бутлуурт тэжээгдэнэ. Бутлагдсан нүүрс нь

доргиурт шигшүүрийн доорх -50мм-ийн ширхэглэлтэй нүүрстэй нэгдэн угаан ангилан тунаах машинд тэжээгдэнэ.

**Нүүрс угаан баяжуулах хэсэг:**Тунаах машины тэжээл дэх хатуу шингэний харьцаа 1:1.5 байхаар тохируулж өгөх ба усны зарцуулалт хэмжээнээсээ ихэсвэл угаасан нүүрсний чанар алдагдана. Тунаах машины техникийн үзүүлэлт өөр өөр байдгаас, хүлээн авах нүүрсний ширхэглэлийн хэмжээ ч өөр байх ба угаасан сайн чанарын эрчим хүчний нүүрс, завсрын бүтээгдэхүүн, хоосон чулуулаг хаягдал гэсэн 3 фракцад ангилна.

Тунаах машин нь дотроо 2 секцээс бүрдэнэ. Тэжээх нүүрсийг тунаах машины дээд талаас өгөх ба хүнд хоосон чулуулаг нь хүндийн жингээрээ эхний секцэд сууна. Харин хөнгөн завсрын бүтээгдэхүүн нь хөвөн 2 дахь секцийн босгыг даван орох замаар тунаан баяжуулалт явагдах бөгөөд цэвэр нүүрс нь тунаах машины босгыг даван усгүйжүүлэх шигшүүрт өгөгдөнө.

Тунаах машины эхний секцэд тунасан хоосон чулуулаг болон хаягдал нүүрс нь тунаах машины доор байрлах усгүйжүүлэх эльватороор зөөгдөн хаягдана.

Баяжуулсан нүүрсийг чичиргээт шигшүүрээр шигшин ангилж усгүйжүүлэх ба шигшүүрийн нүх нь 0.5мм байна. Чичиргээт шигшүүрэн дээрх бүтээгдэхүүн болох +0.5 мм-ийн ширхэглэл бүхий баяжуулсан нүүрсийг хоёр дахь шатны төвөөс зугтах хүчний усгүйжүүлэх төхөөрөмжөөр оруулж эцсийн баяжуулсан нүүрсийг гаргаж авна.

Төвөөс зугтах хүчний төхөөрөмжийн шингэн хаягдал болон -0.5мм-ийн ширхэглэлтэй нүүрсний лаг бүхий ус нь зумпид хуримтлагдах ба насосын тусламжтайгаар гидроциклонд шахагдан ширхэглэлийн хувьд дахин ангилагдана.

Гидроциклоны халиа нь хаягдал өтгөрүүлэгчрүү өгөгдөх ба элс нь усгүйжүүлэх шигшүүрээр дамжин угаасан нүүрсний туузан дамжуулагчид өгөгдөн баяжмал усгүйжүүлэх төвөөс зугтах хүчний төхөөрөмжид өгөгдөн сайн чанарын эрчим хүчний нүүрсний овоолгод хуримтлагдана.

Тунаах машинд угаагдан ангилагдсан сайн чанарын эрчим хүчний нүүрс нь өөрийн урсгалаар усгүйжүүлэх шигшүүрт өгөгдөнө.

Усгүйжүүлэх шигшүүрт усгүйжсэн цэвэр нүүрс нь туузан дамжуулагчаар тээвэрлэгдэн төвөөс зугтах хүчний усгүйжүүлэгчид өгөгдөнө. Төвөөс зугтах хүчний усгүйжүүлэгч төхөөрөмжид усгүйжсэн сайн чанарын эрчим хүчний нүүрсний чийглэг 6-10% байна.

**Хаягдлын аж ахуйн хэсэг:**Хяналтын усгүйжүүлэх шигшүүрийн доод шаварлаг устай хэсэг нь өөрийн урсгалаар хаягдал өтгөрүүлэгчид орно.Өтгөрүүлэгчийн халиаг цэвэршүүлэх лагыг суулгах зориулалттай ус цэвэршүүлэгч PAC, ALCL<sub>3</sub> гэсэн 2 төрлийн бодисыг нэг ээлжэндээ 1-2 шуудайг фоликулянт холигчид найруулан усаар шингэлэн өтгөрүүлэгчид тэжээх юм.


Өтгөрүүлэгч нь усгүйжүүлэх шигшүүрийн доорх булинга, нунтаг хаягдлыг өтгөрүүлэх ба халианы ус нь турбо хоолойгоор урсан технологийн усан санд орно.

Өтгөрүүлэгчид өтгөрч суусан нунтаг хаягдлыг өндөр даралтын насосын тусламжтайгаар шүүн шахах төхөөрөмжид шахаж нунтаг хаягдлыг хатуу кек болгон хаях ба чийглэг нь 18-20%-тай байна.

Шүүн шахах төхөөрөмжөөс гарсан хаягдал ус, булингыг өтгөрүүлэгчид дренажийн тусламжтайгаар өгөх ба усыг нь үйлдвэрлэлд дахин ашиглана.



Нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн барилга



Зураг 3. Нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн технологийн хэсэг

### Нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, ажлын горим

Угаан баяжуулах үйлдвэр нь тасралтгүй ажиллагаатай байх ба Монгол Улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногууд, цаг агаарын байдлын улмаас саатах, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засвар үйлчилгээ, сул зогсолтын хоногууд болон техник, тоног төхөөрөмж ашиглалтын коэффициент, цаг ашиглалтын коэффициент зэргийг тооцсон.

Нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн 2023 оны төлөвлөлт

Үзүүлэлт	Ордын төрөл	Хэмжих нэгж	Жилийн төлөвлөгөө	1-р улирал				2-р улирал				3-р улирал				4-р улирал					
				1	2	3	Дүн	4	5	6	Дүн	7	8	9	Дүн	10	11	12	Дүн		
Баяжуулах үйлдвэрт нийлүүлэх түүхий нүүрсний хэмжээ	Алаг толгод-1	мян. тн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0		
	Алаг толгод	мян. тн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
	Далан	мян. тн	450	10	20	50	80	50	50	50	150	50	50	50	150	40	20	10	70		
	Нийт	мян. тн	450	10	20	50	80	50	50	50	150	50	50	50	150	40	20	10	70		
Баяжуулсан эцсийн бүтээгдэхүүн /А-зэргийн нүүрс/ Экспортонд гаргах нүүрс	Алаг толгод-1	мян. тн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
	Алаг толгод	мян. тн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Далан	мян. тн	180	4	8	20	32	20	20	20	60	20	20	20	60	16	8	4	28		
	Нийт	мян. тн	180	4	8	20	32	20	20	20	60	20	20	20	60	16	8	4	28		
Баяжуулсан завсрын бүтээгдэхүүн /В-зэргийн нүүрс/	Алаг толгод-1	мян. тн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	
	Алаг толгод	мян. тн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Далан	мян. тн	138	3	6	15	24	15	15	15	45	15	15	15	45	15	6	3	24		

Дотоодод борлуулах нүүрс	Нийт	мян. тн	138	3	6	15	24	15	15	15	45	15	15	15	45	15	6	3	24
Өмнөх онд Баяжуулсан эцсийн бүтээгдэхүүн ий үлдэгдэл /А-зэргийн нүүрс/ Экспортонд гаргах нүүрс	Алаг толгод-1	мян. тн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Алаг толгод	мян. тн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Далан	мян. тн	20	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Нийт	мян. тн	20	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Өмнөх онд Баяжуулсан завсрын бүтээгдэхүүн ий үлдэгдэл /В-зэргийн нүүрс/ Дотоодод борлуулах нүүрс	Алаг толгод-1	мян. тн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Алаг толгод	мян. тн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Нийт	мян. тн	135	3	6	15	24	15	15	15	45	15	15	15	45	12	6	3	21
Экспортонд гаргах нүүрс	Нийт	мян. тн	200	28	12	20	40	20	20	20	60	20	20	20	60	20	12	8	40
Дотоодод борлуулах нүүрс	Нийт	мян. тн	135	3	6	15	24	15	15	15	45	15	15	15	45	12	6	3	21
Нийт борлуулах нүүрс		мян. тн	335	31	18	35	64	35	35	35	105	35	35	35	105	32	18	11	61

Санхүү үр дүнгийн үзүүлэлт

<b><u>Үндсэн үйл ажиллагааны үйлчилгээний орлого</u></b>	<b>сая.төг</b>	<b><u>18 530,0</u></b>
<b><u>Нийт орлого</u></b>	<b>сая.төг</b>	<b><u>2 700,0</u></b>
НӨАТ	сая.төг	<u>245,45</u>
<b><u>Цэвэр борлуулалтын орлого</u></b>	<b>сая.төг</b>	<b><u>20 984,55</u></b>
<b><u>Түүхий эд материалын зардал</u></b>	<b>сая.төг</b>	<b><u>4 090,91</u></b>
<b><u>Нийт ашиг</u></b>	<b>сая.төг</b>	<b><u>16 893,64</u></b>
Цалингийн зардал	сая.төг	1 490,0
НДШ-ийн зардал /ААН/	сая.төг	216,05
Түлш, тос, тослох материалын зардал	сая.төг	1 135,9
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээний зардал	сая.төг	132,0
Хоол кемпийн зардал	сая.төг	304,26
Хөдөлмөр хамгааллын зардал	сая.төг	95,5
Цахилгааны зардал	сая.төг	195,55
Тээврийн зардал	сая.төг	6 570,8
Тээвэр зуучлал МТЛ	сая.төг	1 749,0
Дулааны зардал	сая.төг	8,2
Химийн бодисын зардал	сая.төг	32,1
Бусад зардал	сая.төг	100,0
Удирдлагын зардал	сая.төг	250,0
Байгаль орчныг хамгаалах менежмент, мониторингийн зардал	сая.төг	24,0
<b><u>Үйлдвэрлэл, үйл ажиллагааны нийт зардал</u></b>	<b>сая.төг</b>	<b><u>12 303,36</u></b>
<b><u>Татвар төлбөрүүд</u></b>	<b>сая.төг</b>	<b><u>3 296,35</u></b>
Усны төлбөр	мян.төг	27,75
Гаалийн албан татвар	мян.төг	270,3
Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	24,4
АМНАТөлбөр	мян.төг	2 816,7
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	мян.төг	151,2
Хог хаягдлын төлбөр ба бусад	мян.төг	6,0
<b><u>Хуу, татвар, элэгдлийн өмнөх ашиг</u></b>	<b>мян.төг</b>	<b><u>1 293,93</u></b>
Үндсэн хөрөнгийн э.х.ш	мян.төг	422,8
<b><u>Татварын өмнөх ашиг</u></b>	<b>мян.төг</b>	<b><u>871,13</u></b>
ААНОАТ	мян.төг	87,11
<b><u>Цэвэр ашиг</u></b>	<b>мян.төг</b>	<b><u>784,02</u></b>

2023 онд 20.984.550.000 төгрөгийн борлуулалт хийж, 12.303.360.000 төгрөгийн үйлдвэрлэл үйл ажиллагааны зардалтай, 871.130.000 төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллаж, улсад 3.296.350.000 төгрөгийг улс орон нутгийн төсөвт оруулж, 784.020.000 төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөсөн.

Баяжуулах үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн гаргалт /2023 онд/

Түүхий нүүрс, мян.тн		450.0
Бүтээгдэхүүн гаргалт хэмжээ		
1	Сайн чанарын эрчим хүчний нүүрс- 40%	200.0
2	Эрчим хүчний нүүрс- 23.1%	135.0
3	Хаягдал хоосон чулуулаг- 25.3%	70.0
4	Нүүрсний лаг-11.6%	45.0

Угаан баяжуулах үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн хүчин чадал, техникийн үзүүлэлтүүд

**Хацарт бутлуур:** Анхан шатны хацарт бутлуур нь ширхэглэлийн хэмжээг -200мм доош хэмжээнд хүртэл бутална.

Анхан шатны бутлуурын техникийн үзүүлэлт

№	Тодорхойлолт	Үзүүлэлт
1	Хацарт бутлуур	PE-600*900
2	Тэжээх мөхлөгийн хэмжээ, мм	500
3	Гарах мөхлөгийн хэмжээ, мм	65-180
4	Бутлуурын хүчин чадал, тн/цаг	240
5	Хөдөлгүүрийн эргэлт, мин/эрг	990
6	Хөдөлгүүрийн чадал, кВт	75



**Сам шигшүүр:** Сам шигшүүр нь бүтээл өндөр, материал өөрийн урсгалаар шигшигдэн хүлээн авах бункерыг тэжээлээр тасралтгүй хангах зориулалттай шигшүүр юм.

Сам шигшүүр техникийн үзүүлэлт

№	Тодорхойлолт	Үзүүлэлт
1	Тоног төхөөрөмжийн марк	Сам шигшүүр
2	Бүтээл, тн/ц	330
3	Тэжээлийн мөхлөгийн хамгийн том ширхэглэл, мм	200мм
4	Шигшүүрийн өнцөг/ α	27
4	Овор хэмжээ, мм /Урт*Өргөн*Өндөр/	4400x4000x200 0
5	Жин, кг	1500





**Тэргэнцэр тэжээгүүр:** -200мм-ийн ширхэглэлийн хэмжээтэй бункердэх хуримтлагдсан түүхий нүүрсийг тэжээгүүрийн хөдөлгүүрийн давтамжийг ихэсгэж багасган үйлдвэрийн хүчин чадлыг тохируулдаг.

*Тэргэнцэр тэжээгүүрийн техникийн үзүүлэлт*

№	Тодорхойлолт	Үзүүлэлт
1	Тоног төхөөрөмжийн марк	К-3
2	Бүтээл, тн/ц	330
3	Давтамж, эрг/мин	62
4	Хөдөлгүүрийн марк	ҮВ160М-6
5	Хөдөлгүүрийн эргэлтийн хурд эрг/мин	970
6	Хөдөлгүүрийн чадал, кВт	7.5
7	Тэжээлийн мөхлөгийн хамгийн том ширхэглэл, мм	200



**Соронзон металл ялгагч:** Шигшин ангилах доргиурт шигшүүрт түүхий нүүрсийг туузан дамжуулагчийн тусламжтайгаар тэжээх ба туузан дамжуулагч нь түүхий нүүрсэн дэх хаягдал төмөр ялгах соронзон ялгагч тавьсан юм.

*Соронзон металл ялгагч техникийн үзүүлэлт*

№	Тодорхойлолт	Үзүүлэлт
1	Тоног төхөөрөмжийн марк	Металл ялгагч
2	Бүтээл, тн/ц	0.001-0.002
3	Тэжээлийн мөхлөгийн хамгийн том ширхэглэл, кг	5
4	Овор хэмжээ, мм /Урт*Өргөн*Өндөр/	1000x1000x1000
5	Жин, кг	150



**Доргиурт шигшүүр:** Угаан баяжуулах үйлдвэрт анхан шатны шигшин ангилах тоног төхөөрөмжөөр доргиурт шигшүүрийг сонгосон бөгөөд шигших торны нүхний хэмжээ нь 50мм байх ба -50мм-ийн ширхэглэлтэй нүүрсийг нэвтрүүлнэ.

Доргиурт шигшүүрийн тэжээлийн туузан дамжуулагчийн үзүүлэлт

№	Тодорхойлолт	Үзүүлэлт
1	Шигших төхөөрөмжийн марк	ҮК1535
2	Хөдөлгүүрийн эргэлт, эрг/мин	5.25
3	Ажлын тавцангийн тоо	1
4	Торны хэмжээ, мм	50
5	Тэжээх мөхлөгийн хэмжээ, мм	200
6	Хүчин чадал, м <sup>3</sup> /ц	200
7		970
8	Далайц, мм	8
9	Хөдөлгүүрийн чадал, кВт	11



**Булт бутлуур:** Шигшүүрийн дээрх +50мм, -200мм-ийн ширхэглэл бүхий түүхий нүүрсийг туузан дамжуулагчаар булт бутлуурт тэжээх ба хөдөлгүүрийн давтамжийг багасган туузан дамжуулга дээрээс гар аргаар байгалийн хоосон чулууг ялган хаяж, үлдсэн хэсгийг нь -50мм-ийн бүтээгдэхүүн болтол бутлан шигшигдсэн нүүрстэй туузан дамжилга дээр нэгдэн угаан баяжуулах хэсэгрүү тээвэрлэгдэнэ.

Дунд шатны булт бутлуурын техникийн үзүүлэлт

№	Тодорхойлолт	Үзүүлэлт
1	Бутлуурын марк	2PLF70/80
2	Тэжээх мөхлөгийн хэмжээ, мм	300
3	Гарах мөхлөгийн хэмжээ, мм	50-60
4	Бутлуурын хүчин чадал, тн/ц	80
5	Хөдөлгүүрийн чадал, кВт	2*18.5



**Усгүйжүүлэх шанагат эльватор:** Эльватор нь тунаах машины доод гаралтын хэсэгт суурилагдах бөгөөд завсрын бүтээгдэхүүн болон хаягдал чулуулгийг зайлуулах болон усгүйжүүлэх зориулалттай.

Тунаах машины техникийн үзүүлэлт

№	Тодорхойлолт	Үзүүлэлт
1	Тоног төхөөрөмжийн марк	SKT-16
2	Тэжээх нүүрсний хамгийн том ширхэглэл, мм	0-50
3	Боловсруулах хүчин чадал, тн/м <sup>2</sup> *ц	10-20
4	Усны даралт, МПа	10
5	Шахах агаарын даралт, МПа	0.4-0.6
6	Тунаах машины ажлын талбай, /Хаягдал/ м <sup>2</sup>	6.4
7	Тунаах машины ажлын талбай, /Нүүрс/ м <sup>2</sup>	9.6
8	Хаягдлын камерын торны нүхний хэмжээ, мм	16-19
9	Нүүрс ялгах торны нүхний хэмжээ, мм	13-16
10	Хаягдлын камерын торны өнцөг, градус	3
11	Нүүрсний камерын торны өнцөг, градус	1.5
12	Давтамж, мин	30-90
13	Хөдөлгүүрийн чадал, кВт	2*5.5
14	Үлээгч /агаарын хэмжээ/	>120
15	Үлээгч /агаарын даралт/ МПа	>0.035
16	Үлээх даралт /агаарын хэмжээ/	1.8
17	Үлээх даралт /агаарын даралт/ МПа	0.8

Эльваторын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлт
1	Эльваторын марк	T4080
2	Тэжээлийн хамгийн том ширхэглэл, мм	100
3	Шанаганы өргөн, мм	400
4	Эльваторын өргөн, мм	800
5	Эльваторын урт, м	11.8
6	Суурилуулалтын налуу, °	55-70
7	Эльваторын эргэлтийн хурд м/с	0.27
8	Эльваторын хүчин чадал тн/ц	80
9	Хөдөлгүүрийн марк	Y180L-4
10	Хөдөлгүүрийн чадал, кВт	15
11	Тоо ширхэг	2



**Усгүйжүүлэх доргиурт шигшүүр:** Тунаах машинаас гарах сайн чанарын эрчим хүчний нүүрсийг 0.5мм, 0.25мм усгүйжүүлэх шигшүүрээр шигшинэ.

Угаагдсан цэвэр нүүрс усгүйжүүлэх шигшүүр

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлт
1	Усгүйжүүлэх шигшүүрийн марк	ZK3048
2	Шигшүүрийн ажлын талбай, м <sup>2</sup>	14.4
3	Шигшүүрийн торны хэмжээ, мм	0.25-50
4	Хамгийн том мөхлөгийн ширхэглэл, мм	250
5	Бүтээл, тн/ц	29-580
6	Хөдөлгүүрийн эргэлтийн хурд, эрг/мин	890
7	Далайц, мм	9.5
8	Хөдөлгүүрийн чадал, кВт	44
9	Жин, кг	9900



**Гидроциклон:** Төвөөс зугтах хүчний төхөөрөмжийн шингэн хаягдал болон -0.5мм–ийн ширхэглэлтэй нүүрсний лаг бүхий ус нь зумпид хуримтлагдах ба насосын тусламжтайгаар гидроциклонд шахагдан ширхэглэлийн хувьд дахин ангилэгдана. Нэг шигшүүрийн дээр 3ш гидроциклон тавьсан ба нийт 6ш гидроциклоноор ангилж байна.

Гидроциклон техникийн үзүүлэлт


№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлт
1	Гидроциклоны марк	FX300
2	Диаметр, мм	300
3	Конусын өнцөг, градус	20
4	Халианы диаметр, мм	65-115
5	Элсний диаметр, мм	20-50
6	Хамгийн том мөхлөг, мм	0.5
7	Тэжээлийн даралт, МПа	0.04-0.3
8	Хүчин чадал, м <sup>3</sup> /ц	100
9	Жин, кг	105



**Центрифуга:** Гидроциклоны элс нь усгүйжүүлэх шигшүүрээр дамжин угаасан нүүрсний туузан дамжуулагчид өгөгдөн баяжмал дахин төвөөс зугтах хүчний төхөөрөмжид усгүйжүүлэн (9-10)%-ийн чийг бүхий эцсийн бүтээгдэхүүнийг гаргаж авна.

Усгүйжүүлэх центрифугийн техникийн үзүүлэлт

№	Центрифугийн марк	WL1200
1	Максимум хүчин чадал, т/ц	150
2	Цахилгаан хөдөлгүүрийн чадал, кВт	43.75
3	Аяганы диаметр, мм	1500
4	Аяганы налууугийн өнцөг	15 <sup>0</sup>
5	Торны нүхний хэмжээ, мм	0.5
6	Аяганы эргэх хурд, rpm	290
7	Ашиглах тоо	1



**Флокулянт:** Өтгөрүүлэгч дэх булингыг цэвэршүүлэх лаг суух хугацааг хурдасгах зориулалттай химийн бодисыг найруулан өтгөрүүлэгчид жигд хурдаар тасралтгүй тэжээнэ.

Флокулянт зуурагч техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлт
1	Флокулянтын марк	ЖТВ1.5
2	Флокулянтын диаметр, м	1.5
3	Эзлэхүүн, м <sup>3</sup>	3.768
4	Өндөр, м	1.6
5	Хүчин чадал, м <sup>3</sup> /ц	400-450
6	Хөдөлгүүрийн чадал, кВт	4
7	Найруулж буй бодис1	ALCL <sub>3</sub>
8	Найруулж буй бодис2	РАС
9	Бодисын хатуу шингэний харьцаа кг/тн	3/1000





**Өтгөрүүлэгч:** Үйлдвэрийн технологиос гарч буй булингыг өтгөрүүлэн шүүн шахах төхөөрөмжид өгөх ба цэвэршсэн халианы ус нь усан санд орон эргэлтийн ус болон үйлдвэрт ашиглагдана.

*Хаягдал өтгөрүүлэгчийн техникийн үзүүлэлт*

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлт
1	Өтгөрүүлэгчийн марк	GSM-30
2	Өтгөрүүлэгчийн диаметр, м	10
3	Өтгөрүүлэгчийн ажлын талбай, м <sup>2</sup>	78.5
4	Өндөр, м	9
5	Хүчин чадал, м <sup>3</sup> /ц	400-450
6	Хөдөлгүүрийн чадал, кВт	5.5
7	Өтгөрүүлэгчийн эзлэхүүн, м <sup>3</sup>	380
8	Хүлээн авах мөхлөгийн ширхэглэл, мм	0-50
9	Түүхий эдийн хатуу шингэний харьцаа, г/л	50-80
10	Өтгөрүүлэгчээс гарах бүтээгдэхүүний Х:Ш –ний харьцаа гр/л	>200



**Фильтр пресс:** Өтгөрүүлэгчээс гарсан материалын усыг үйлдвэрт эргэлтээр ашиглах зорилгоор шүүн шахаж 18-20% тай нунтаг кек болгоно.

*Фильтр прессийн техникийн үзүүлэлт*

№	Үзүүлэлтийн нэр	Үзүүлэлт
1	Марк	ХМЗ400/1600
2	Шүүх талбай, м <sup>2</sup>	400
3	Хавтангийн хэмжээ, мм	1600*1600
4	Хавтангийн зузаан, мм	35
5	Шүүх хавтангийн тоо	99
6	Даралт, мРа	0.6
7	Хөдөлгүүрийн чадал, кВт	5.5+1.1
8	Овор хэмжээ, мм	9880*2200*1900
9	Жин, кг	32574



Үзүүлэлт	LIUGONG
Утгуурын багтаамж, м <sup>3</sup>	4
Мөчлөгийн хугацаа, с	28
Ачилт хийх хамгийн их өндөр, мм	5180
Ачилт хийх өндөр, мм	4265
Их биеийн өргөн, мм	3000
Их биеийн урт, мм	7430
Их биеийн өндөр, мм	3310
Арын эргэлтийн радиус, мм	3610
Хөдөлгүүрийн төрөл	CLG855H
Масс, кг	18100
Хөдөлгүүрийн чадал, м.х	245



### Химийн бодис түүний хэрэглээ

Нүүрс угаах үйлдвэрт Полиакриламид ( $\text{CH}_2 \text{CHCONH}$ ) төрлийн фоликулянт бодисыг зориулалтын саванд найруулан хаягдал өтгөрүүлэгчид 1тн нүүрсэнд 30-40мг байхаар тунгийн нь тааруулан тэжээнэ. Тухайн бодисыг тунгаагуур дахь лагийг түргэн хугацаанд суулгах эргэлтийн усыг бүрэн гүйцэд цэвэрлэх зориулалтаар ашигладаг ба жилд бүрэн хүчин чадлаараа ажиллавал 65 тн бодис хэрэглэнэ.



Фоликулянт бодис холигч



№	Бодис зарцуулах горим	Зарцуулах бодисын хэмжээ /кг
1	1/тн нүүрс угаахад	0.4
2	Цагт	9.6
3	Ээлжинд	96
4	Хоногт	192
5	Сард	4992
6	Жилд	65000

### Усан хангамж

Тус үйлдвэрийн хэмжээнд нийт 4 худаг ашиглахаар төлөвлөсөн ба WSA-1 нь баяжуулах үйлдвэрийн чанх урд 1111 метр орчим зайд байрлах WSA-2 нь худаг WSA-1-ийн баруун урд зүгт 110 орчим метр зайтай юм. WSA-1,2 -оос баяжуулах үйлдвэрийн дэргэд байрлах 170м<sup>3</sup> эзлэхүүнтэй цэвэр усны нөөцийн сав хүртэл 1100 метр орчим урттай ус дамжуулах шугам хоолойг барьж байгуулсан ба усны шугамыг газар ухаж, хөлдөлтийн бүсээс доогуур татсан.

Уурхайн захиргаа, ажилчдын амьдрах байр сууц болон уурын зуухны усны хэрэгцээг мөн адил гүний худаг-2-аас хангаж байна.

2023 онд үйлдвэрийн зориулалтаар ашиглахаар Худаг-1, Худаг-2 гэсэн 2 цооногийг шинээр гаргасан.Худаг-1 цооног нь баяжуулах үйлдвэрээс баруун урд 150 метрт, Худаг-2 цооног нь 300 метрт тус тус байрлалтай байна.

Унд ахуйн хэрэгцээний усыг WSA-1, WSA-2 худгаас хангахаар төлөвлөсөн бөгөөд худгийн усны дээжийг шинжлүүлэхэд хатуулаг ихтэй ахуйн зориулалтаар ашиглах тохиромжгүй байгаа тул тусгай зориулалтын ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулан ашиглаж байна. Усны тухай хуулийн дагуу усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийг тогтоож хамгаалалтын хашаа байгууламж барьсан.



WSA-1 худаг



WSA-2 худаг



2023 онд өрөмдөж гаргасан худаг-1 цооног



2023 онд өрөмдөж гаргасан худаг-2 цооног

**Ахуйн усны хэрэглээ:** Унд ахуйн хэрэгцээний усыг үйлдвэрийн урд талд байрлах WSA-01, WSA-02 худгуудаас хангаж байгаа бөгөөд худгийн усны дээжийг шинжлүүлэхэд хатуулаг ихтэй байсан тул зориулалтын ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулан ашиглаж байна.

Бид унд ахуйн усны хэрэгцээг тооцохдоо нэг хүний хоногийн усны хэрэглээг 30 л-ээр тооцон ахуйн хэрэглээний усны тооцоог гаргасан ба кэмпд 65 ажилтан байрлан амьдрах юм.

Унд ахуйн усны жилийн хэрэгцээ

№	Тодорхойлолт	Хэмжээ, мян.м <sup>3</sup>
1	Кемп-д байрлан ажиллах хүний тоо	65
2	Ундны цэвэр усны хэрэглээ	384.5
3	Ахуйн усны хэрэглээ	2.248
4	Нийт унд ахуйн усны хэрэглээ	2.632.5

**Нүүрс угааж баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээ, хангамж:** Баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээг тооцон гаргахдаа үйлдвэрийн технологийн дамжлага, схемийн дагуу ус шламын балансын тооцоог хийхэд үйлдвэрийн усны хэрэглээ нь цагт 12.4м<sup>3</sup> буюу хоногийн усны хэрэгцээ 210.8 м<sup>3</sup> орчим усны их үүсвэр шаардлагатай байгаа ба унд ахуйн ус, уурын зуухны ус нийлээд цагт 12,67м<sup>3</sup> хоногт 215.48м<sup>3</sup> ус зарцуулна.

Үйлдвэрлэлийн жилийн усны хэрэгцээ

№	2023 оны ашиглах усны хэрэглээ /Усны газрын 126 тоот ус ашиглуулах дүгнэлт/	Хэмжээ, мян м <sup>3</sup>
1	Үйлдвэрийн технологийн усны хэрэгцээ	99.674.4
2	Унд ахуйн усны хэрэглээ	2.632.5.
3	Ногоон байгууламжийн усалгаа	630.0
4	Зам талбайн усалгаа	6000.0
5	<b>Нийт усны хэрэглээ</b>	<b>108.937</b>

### Дээж авалт, сорьцлолт хяналт

Лаборатор нь анхдагч түүхий нүүрс болон үйлдвэрээс гарч буй бүтээгдэхүүн тус бүрээс дээж авч шинжилгээг хийнэ.

Дээж авахдаа 2 цаг тутамд туузан конвейр дээрээс гар аргаар дээж аван шинж чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлж үйлдвэрийн технологийг жигд явуулахад хяналт тавьж ажиллана. Лаборатори илчлэг, чийглэг, дэгдэмхий, хүхэр, үнслэгийн хэмжээг тодорхойлох шинжилгээг 24 цагийн турш гүйцэтгэн ажиллах бөгөөд тоног төхөөрөмжийн цахилгаан зарцуулалт нь 30кВт/ц байна.

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк, үзүүлэлт
1	Жинлүүр	30kg, 0.2kg
2	Дээж хуваагч	SFQ-1
3	Стандарт ком шигшүүр	Ф200mm,6давхар,240удаа/мину т
4	Цахилгаан хатаагч	101A-2
5	Бутлуур	EP-2,100x60
6	Цахилгаан хатаах шүүгээ	DHG-9140AH марк,N=3.6kW
7	Хатаагч	DL-5 марк,N=0.2kW
8	Аналитик жин	BSA124S марк,120g,0.0001g
9	Электрон жинлүүр	YP 3001 марк,3000g,0,1g
10	Үнслэг тодорхойлох багаж	DST-1D марк ,N=4kW,220V
11	Хүхэр шинжлэх багаж	DS-DLA AC220V, 3.5KW
12	Зуух	SRJX-4-9 марк ,t=160°C,N=4kW
13	Дэлгэцэт цахилгаан хатаагч	101A-2
14	Бүрэн автомат температур хэмжигч	ZDHW-5
15	Илчлэг тодорхойлох багаж	DS-RA, AC220V , 50W

**Лабораторийн мөрдөж ажиллах стандартууд:**

1. Хүрэн, чулуун нүүрс, антрацит ба шатах занар чийгийг тодорхойлох арга MNS 0655:1979
2. Хатуу эрдэс түлш үнслэг тодорхойлох арга MNS ISO 1171:2009
3. Чулуун нүүрс ба кокс- дэгдэмхий бүдсийн гарцийг тодорхойлох  
MNS ISO 562 : 2001
4. Нил улаан туяаны спектрометрээр хатуу түлшний хүхрийн хэмжээг тодорхойлох  
MNS ISO 19579:2014
5. Хатуу эрдэс түлшний илчлэгийн нийт утгыг бортогон калориметрийн аргаар тодорхойлох ба илчлэгийн цэвэр утгыг тооцоолох арга MNS ISO 1928:2009

**Сорилтын туршилтын гадаад ба дотоод хяналт:**

Лабораторид хийгдэж байгаа сорилт шинжилгээний эцсийн үр дүнгийн үнэн зөв, бодит баталгаатай байдал, шинжилгээг хэвийн явуулах нөхцөлийг хангахад дотоод хяналтын зорилго оршино.

Чанарын дотоод хяналтын ажиллагаа нь дараах зүйлсийн дагуу явуулна.

- Сорилтыг тогтмол хоёр зэрэгцээ гүйцэтгэх
- Стандчилсан заавар тогтмол хэрэглэх



- Ажилтан үл мэдэх дээжийг тогтмол дагалдуулан шинжлүүлэх
- Шинжилсэн дээжний 10-аас дээшгүй хувийг санамсаргүй байдлаар түүвэрлэн давтан шинжлэх
- Шинжилгээний хяналтыг дууссаны дараа шууд шалгавал зохино. Хяналтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу хийх ёстой ба хяналтын давтамжинд жил бүр дүн шинжилгээ хийнэ.
- Өдөр тутамд хийгддэг шинжилгээнд нийт сорьцын 5-аас багагүй хувьд (сорьц тутмын 1 нь чанарын хяналтын сорьц байх) дотоод чанарын хяналтыг гүйцэтгэнэ.

Гадаад хяналт чанарын дотоод хяналт нь лабораторид хийгдэж байгаа шинжилгээний үр дүн үнэн зөв гэдгийг батлахад оршино. Лабораторийн ажлын чанар амжилттай хэрэгжиж байхын тулд сард нэгээс доошгүй удаа чанарын гадаад хяналтанд хамрагддаг.

Лаборатори хоорондын хяналтаар өндөр чадвартай буюу үр дүн нь олон улсад хүлээн завшөөрөгдсөн лаборатори луу өөрийн лабораторид шинжилсэн дээжний тодорхой хувийг явуулан шинжлүүлж, үр дүнг харьцуулан шинжилгээнийхээ ажлын чанарын түвшингийн талаар мэдээлэл авдаг.

Үүнд: “SGS” IMME, “ASL” LLC, “BV” LLC, “Ашигт малтмалын газар” зэрэг лабораториудтай сар бүр зэрэгцээ туршилтын таарцаар шалган гадаад хяналтыг явуулна.

### Тээвэр

Түүхий нүүрс тээвэрлэлтийг үйлдвэрийн бункерт ойр нүүрс нөөцлөх талбайд нөөцийн нүүрсийг тасралтгүй автосамосвал, шланз зэрэг тээвэрийн хэрэгсэлээр явуулна. Үйлдвэрээс эцсийн бүтээгдэхүүн болон гарч буй сайн чанарын эцсийн бүтээгдэхүүнийг 1.9 га талбайд овоолго үүсгэн хуримтлуулна. Сайн чанарын эрчим хүчний нүүрсийг БНХАУ-д экспорлох ба дунд зэргийн эрчим хүчний нүүрсийг дотоодын үйлдвэрлэлүүдэд нийлүүлэн хоногийн ачаа урсгал хамгийн багадаа хоногт 1800-2000 тн орчим байна.

Эцсийн болон завсрын бүтээгдэхүүний талбайгаас 70тн-ын даацтай HOWO шланзанд утгуурт ачигчаар ачин үйлдвэрээс 18км-ын зайд байрлах вагон ачилтын талбай орох сайжруулсан шороон замаар тээвэрлэнэ. Хоногт нэг шланз 6-8 рейс явах ба нийт 5-6 шланзаар тээвэрлэлт хийнэ.



Түүхий нүүрс нөөцлөх талбай



Эцсийн бүтээгдэхүүн ачилтын талбай

Үйлдвэрээс гарах хоосон чулууллаг буюу хаягдлыг хөрсний овоолгод хуримтлуулан байгалийн хотгор газрыг ашиглан 6.3 га талбайд 25тн автосамосвал тээвэрлэн утгуурт ачигч бульдозер ашиглан овоолго үүсгэнэ. 2. Завсарын бүтээгдэхүүнийг үйлдвэрийн баруун талд 600 м зайд автосамосвал тээвэрлэн шинж чанараар нь ангилан ялгалт хийн овоолго үүсгэнэ.

Үйлдвэрээс гарч буй 18-20%-ийн чийглэгтэй хатуу хаягдал болгох ба нунтаг хатуу хаягдлыг утгуурт ачигчаар тээврийн машинд ачиж үйлдвэрийн талбайгаас 1800 м зайд гарган 6.3 га талбайд овоолго үүсгэнэ. Хаягдлын овоолгод хуримтлагдах лаг(кек) нь үйлдвэрийн технологоос барьцалдсан шинж чанар агуулагдан гарах ба хатсан лаг нь блок мэт хатуу хаягдал үүсэх ба тоос үүсэхгүй байгаль орчинд нөлөөлөх хүчин зүйл үзүүлэхгүй юм.



Хоосон чулууллаг буюу хаягдалын овоолго



Завсарын бүтээгдэхүүний овоолго



Лагийн овоолго

Баяжуулах үйлдвэрийн технологийн хаягдал 2023 он

№	Үзүүлэлт	Хэмжээ мян.тн
<b>Түүхий эдийн хэмжээ</b>		
1	Түүхий нүүрс	450.0
<b>Хаягдалын хэмжээ</b>		
2	Хоосон чулуулаг	70.0
3	Лаг	45.0
<b>Нийт хаягдал</b>		<b>115.0</b>

### Овоолгын технологи

Гадаад овоолгыг баяжуулах үйлдвэрийн зүүн урд хэсэгт 1800 м зайд дагуулан байршуулж хоосон чулуулаг, лагийн овоолго байгуулахаар тооцлоо. Мөн үйлдвэрийн баруун урд талд завсарын бүтээгдэхүүний овоолго тус тус үүсгэх юм. Нүүрсний овоолгын өндөр 5м байхаар байгуулна. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хаягдалыг дахин ашиглах, завсарын бүтээгдэхүүний чийг өндөр тул байгалийн аргаар хатаах процес явуулж дотоодын эрчим хүч, цахилгаан дулааны үйлдвэрүүдэд нийлүүлэнэ. Овоолгын хажуугийн өнцөг нь физик механик шинж чанараас хамааран 33-38° байхаар тооцоолсон.

### Үйлдвэрийн дотоод дамжуулалтын систем


Үйлдвэрийн тээврийн систем нь урт, богино нийлсэн 9 ширхэг туузан конвейер, шингэн материалт тээвэрлэхэд зориулагдсан шахуурга бүхий хоолойнууд, нунтаг лаг тээвэрлэх гинжит конвейер, хоосон чулуу, завсарын бүтээгдэхүүн тээвэрлэх усгүйжүүлэх элватор зэргээс бүрдэнэ.

**Конвейерын сонголт, техникийн үзүүлэлт:** Конвейер нь үйлдвэрийн тасралтгүй ажиллагаатай тээврийн машины төрөлд хамаарагдана. Туузан конвейер нь бүтээмж өндөртэй, энгийн хийцтэйгээрэ давуу талтай.

Туузан дамжуулагчийн үзүүлэлт-1

№	Тодорхойлолт	Үзүүлэлт	
1	Тоног төхөөрөмжийн марк	B-1000	
2	Бүтээл, тн/ц	200	
3	Хөдөлгүүрийн чадал	37	
4	Эргэлтийн хурд, м/с	1.6	
5	Туузны өргөн, мм	1000	
6	Туузан дамжуулагчийн урт, м	17	
7	Туузан дамжуулагчийн налуу, °	17	

Туузан дамжуулагчийн үзүүлэлт-2


№	Тодорхойлолт	Үзүүлэлт	
1	Тоног төхөөрөмжийн марк	B-1000	
2	Бүтээл, тн/ц	200	
3	Хөдөлгүүрийн чадал	37	
4	Эргэлтийн хурд, м/с	980	
5	Туузны өргөн, мм	1000	
6	Туузан дамжуулагчийн урт, м	33.8	
7	Туузан дамжуулагчийн налуу, °	17	



Туузан дамжуулагчийн үзүүлэлт-3

№	Тодорхойлолт	Үзүүлэлт	
1	Тоног төхөөрөмжийн марк	B-1200	
2	Бүтээл, тн/ц	80	
3	Хөдөлгүүрийн чадал	5.5	
4	Эргэлтийн хурд, м/с	960	
5	Туузны өргөн, мм	1200	
6	Туузан дамжуулагчийн урт, м	7	
7	Туузан дамжуулагчийн налуу, °	180	


Туузан дамжуулагчийн үзүүлэлт-4

№	Тодорхойлолт	Үзүүлэлт	
1	Тоног төхөөрөмжийн марк	B-800	
2	Бүтээл, тн/ц	200	
3	Хөдөлгүүрийн чадал	37	
4	Эргэлтийн хурд, м/с	980	
5	Туузны өргөн, мм	800	
6	Туузан дамжуулагчийн урт, м	36.6	
7	Туузан дамжуулагчийн налуу, °	17	


Туузан дамжуулагчийн үзүүлэлт-5

№	Тодорхойлолт	Үзүүлэлт	Зураг
1	Тоног төхөөрөмжийн марк	B-650	
2	Бүтээл, тн/ц	46.8	
3	Хөдөлгүүрийн чадал	7.5	
4	Эргэлтийн хурд,	1440	
5	Туузны өргөн, мм	650	
6	Туузан дамжуулагчийн урт, м	11.12, 43.5, 9.4	
7	Туузан дамжуулагчийн налуу, °	11,180	

Туузан дамжуулагчийн үзүүлэлт- 6

№	Тодорхойлолт	Үзүүлэлт	
1	Тоног төхөөрөмжийн марк	B-800	
2	Бүтээл, тн/ц	57	
3	Хөдөлгүүрийн чадал	7.5	
4	Эргэлтийн хурд, м/с	1400	
5	Туузны өргөн, мм	800	
6	Туузан дамжуулагчийн урт, м	11.12, 74.5	
7	Туузан дамжуулагчийн налуу, °	11,180	

Туузан дамжуулагчийн үзүүлэлт-7

№	Тодорхойлолт	Үзүүлэлт	
1	Тоног төхөөрөмжийн марк	B-1000	
2	Бүтээл, тн/ц	320	
3	Хөдөлгүүрийн чадал	37	
4	Эргэлтийн хурд, м/с	1470	
5	Туузны өргөн, мм	1000	
6	Туузан дамжуулагчийн урт, м	121.5	
7	Туузан дамжуулагчийн налуу, °	180	

### Барилга байгууламж, дэд бүтэц

Баяжуулах үйлдвэрийн дэргэд ажилчдын амрах байр, оффис, цайны газар, ариун цэврийн өрөө болон амрах талбай зэргийг цогцоор нь нэг дор байгуулахаар 2018 онд төлөвлөн 31х71 метрийн харьцаатай 3 метрийн өндөртэй сендвичэн байрыг ашиглалтанд оруулсан. Уг байр нь ажилчдын тав тух амьдрах орчин нөхцлийг бүрдүүлж өгнө. Үүнд:


- Халаалт, бохир, цэвэр ус,
- Цайны газар,хоолы заал
- Оффис өрөө,хурлын өрөө
- Биллярд теннис,шатар даам,номын өрөө гэх мэт.

**Нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн барилга, байгууламжүүд:** Нүүрс угаан баяжуулах үйлдвэр нь түүхий нүүрс бэлтгэх, угаан ангилах, хаягдал ус дахин боловсруулах болон нүүрс буулгах цэг гэсэн үндсэн 4 хэсгээс бүрдэнэ.

Нүүрс бэлтгэн нийлүүлэх хэсэг нь анхдагч түүхий нүүрсний ширхэглэлээр ангилах, том ширхэглэл бүхий нүүрсийг буталж нэгэн жигд болгон бэлтгэнэ.




Ажилчдын амрах байр, Нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн харагдах байдал




Түүхий нүүрс бэлтгэн нийлүүлэх хэсгийн байр, тоног төхөөрөмжийн харагдах байдал



Баяжуулах үйлдвэр болон уурхайн засварын цех



Нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн үндсэн барилга, тоног төхөөрөмжийн харагдах байдал



Технологийн хаягдал ус дахин боловсруулах хэсгийн байр, тоног төхөөрөмжийн харагдах байдал

**Үйлдвэрийн цахилгаан хангамж:** Нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн эрчим хүчний хэрэглээг “МАК” ХХК-ийн 10 кВ-ийн өндөр хүчдлийн 292 тулгуур шугамаас тэжээж байна.

**Гэрэлтүүлэг:** Үйлдвэрийн гэрэлтүүлэгт шинээр дотор орчны гэрэлтүүлэгийг сайжруулахад ДРЛ ламп бүхий РСП төрлийн 35ш гэрэлтүүлэгч, гадна талбайд 15ш гэрэл

ашиглаж байна. Гэрэлтүүлэгчүүдийг үйлдвэрийн таазанд зохих нормын дагуу жигд, тэгш хэмтэй байрлуулсан. Үйлдвэрийн гэрэлтүүлгийн нормыг  $E_{нор} = 100Лк$  байхаар авав.

Гэрэлтүүлэх гадаргууны талбай

$$S_{np} = B \cdot L = 18 \cdot 36 = 648 м^2$$

$B$  – үйлдвэрийн өргөн, м;

$L$  – үйлдвэрийн урт, м.

УПД ДРЛ гэрэлтүүлэгчийн хувийн чадал  $E_{нор} = 100Лк$  үед  $\rho_{уд} = 14.5Вт / м^2$  байх тул талбайг гэрэлтүүлэхэд шаардагдах нийт тоо 24ш чадал 9396Вт байна.



Уурхайн цахилгаан хангамжийн эх үүсгүүр



Дэд станц

**Дулаан хангамж:** Үйлдвэрийн болон кемпийн дулаах хангамжийг халаалтын тогоо бүхий шугам хоолойн халаалтын системээр цогцоор нь шийдсэн юм. Халаалтын системийг хүйтний улиралд буюу гадна агаарын температур  $+8^{\circ}C$   $-10^{\circ}C$ -аас тогтвортой буурч эхлэхэд халаалтыг ажиллуулж, хавар  $+8^{\circ}C$ -аас тогтвортой дээшилж эхлэхэд халаалтыг зогсооно. Халаалт өгөх хугацаа: 10 сарын 15-ээс 04 сарын 15 хүртэл гэж тусгасан болно.



## **ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ**

“Нүүрс угаан баяжуулах үйлдвэр” төслийн байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар ашиглан олборлолт явуулахад төслийн гол зорилго оршино.

### *Агаарын чанар, түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл*

- Барилга байгууламж барих, үйлдвэрийн бүтээн байгуулалт, зам талбай засах хөрс хуулах, нүүрс тээвэрлэх гэх мэт үйл ажиллагааны үед тоосжилт үүснэ.
- Нүүрс тээврийн хэрэгсэл болон автомашины хөдөлгүүрийн дутуу шаталтын хий нь агаар орчныг хорт хийгээр бохирдуулж болзошгүй.
- Барилга байгууламж барих, төслийн үйл ажиллагаанаас үүдэн чичиргээ доргио, дуу шуугианы бохирдлыг үүсгэж болзошгүй.
- Тоосжилт, хорт хийн ялгаралт, дуу шуугиан гэх мэтээс шалтгаалан төсөл хэрэгжих орчны айл өрхийн амгалан тайван байдал алдагдаж, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлж болзошгүй.

### *Газрын гадарга, хэвлий, хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл*

- Үйлдвэрийн болон ажилчдын барилга байгууламж барих, хаягдал болон нүүрс буулгах талбай засах, тээвэрлэлтийн зам засах зэргээр газрын гадарга, хэвлийд нөлөөлнө.
